



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 5/80

Хэрлэн сум

Түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" тухай 354, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхутаг сумын цэцэрлэгийн эрхлэгч Р.Оюунгэрэл нь ажлаас чөлөөлөгдсөн тул Э.Энхтайванг 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн тус цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Эрхлэгчийн ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг сумын Засаг дарга /Д.Байгалмаа/-д даалгасугай.

3. Цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдож байгаа Э.Энхтайвангийн цалинг ТҮБД-н 6-ын 5 дугаар шатлал 711230 /долоон зуун арван нэгэн мянга хоёр зуун гучин/ төгрөгөөр тогтоож, цалинжуулахыг цэцэрлэгийн нягтлан бодогч /М.Цэнд-Аюуш/-д зөвшөөрсүгэй.

4. Эрхлэгчийн ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА